

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ЗОХИЦУУЛАГЧДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар
Улаанбаатар
сарын 07 өдөр

Дугаар 31

ХОТ

Дүрэм батлах тухай

“Эрчим хүчний тухай” Монгол Улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “УБДС” ТӨХК-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийг нэгдүгээр хавсралтын ёсоор, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийг хоёрдугаар хавсралтын ёсоор, “БНДС” ТӨХК-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийг гуравдугаар хавсралтын ёсоор, “ДДС” ТӨХК-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийг дөрөвдүгээр хавсралтын ёсоор, “ЭДЦС” ТӨХК-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийг тавдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Дүрэм батлагдсантай холбогдуулан хэрэглэгчтэй байгуулсан гэрээндээ зохих нэмэлт, өөрчлөлт оруулж мөрдөхийг “УБДС” ТӨХК /Ш.Баасанжав/, “Даланзадгадын дулааны цахилгаан станц” ТӨХК /Ж.Дуламжав/, “БНДС” ТӨХК /Г.Дагва/, “ДДС” ТӨХК/С.Дэлгэр/, “ЭДЦС” ТӨХК /Ж.Хавдлашим/-д үүрэг болгосугай.

ЗОХИЦУУЛАГЧДЫН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Р. ГАНЖУУР

ЗОХИЦУУЛАГЧ

Г. ДАМДИНСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Б. МӨНХӨӨ

“УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК - ХЭРЭГЛЭГЧ ХООРОНДЫН АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь дулаанаар хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч “УБДС” ТӨХК / цаашид хангагч гэх/- иас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг дулаанаар хангахтай холбогдож үүссэн харилцааг зохицуулах, тэдгээрийн хооронд дулаанаар хангах гэрээ байгуулах нөхцөл, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцөл болон хангагч, хэрэглэгчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү дүрмийг дулаанаар хангах үйл ажиллагааг эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч “УБДС” ТӨХК болон дулаанаар хангагдахаар гэрээ байгуулсан, байгуулахыг хүссэн аж ахуйн нэгж, иргэд дагаж мөрдөнө.

Хоёр. Дүрмийн нэр томъёо

- 2.1. Энэхүү дүрэмд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1. “Хангагчийн эрх бүхий ажилтан”- гэж “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон ажилтныг
 - 2.1.2. “Дулаан хангамжийг түдгэлзүүлэх” - гэж гэрээний үүргээ биелүүлээгүй болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хэрэглэгчийн дулаан хангамжийг тодорхой хугацаагаар зогсоохыг;
 - 2.1.3. “Техникийн нөхцөл”- гэж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дулаанаар хангах зорилгоор тэдгээрийн байр, байгууламж, тоног төхөөрөмжийг дулааны сүлжээнд шинээр холбох, хэрэглэгчийн дулааны ачааллыг нэмэгдүүлэх зорилгоор дулаан түгээх шугам, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбогдсон техникийн шийдлийг тусгасан, хангагчаас дулаан хэрэглэгч буюу дулаанаар хангагдахыг хүссэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон баримт бичгийг;
 - 2.1.4. “Нөхөн тооцоо”- гэж хангагч хэрэглэгчийн болон бусад хуулийн этгээдийн буруутай үйлдлээс шалтгаалан үүссэн дулааны хэрэглээний тооцоо, төлбөрийн зөрүүг арилгах үйл ажиллагааг

Гурав. Хангагч , хэрэглэгчийн хоорондын харилцаа

- 3.1. Хангагч нь Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү дүрэмд нийцүүлэн хэрэглэгчтэй аж ахуйн гэрээ байгуулна
- 3.2. Гэрээ байгуулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь дараахь шаардлагыг хангасан байна:
 - 3.2.1. Хангагчаас олгосон техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан байх
 - 3.2.2. Дулаан хэрэглэсний тооцоог нийлж баталгаажуулж, өр төлбөрөө бүрэн барагдуулсан байх
 - 3.2.3. Шугам сүлжээний эзэмшлийн заагийг хоёр тал харилцан тохиролцож баталгаажуулсан байх
 - 3.2.4. Тоолуур болон хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулсан байх
- 3.3. Хэрэглэгчтэй байгуулах дулаанаар хангах аж ахуйн гэрээнд хэрэглэх дулааны тоо хэмжээ, чанар, үнэ тариф, төлбөр тооцооны журам, гэрээний хугацаа, хүлээх үүрэг, хариуцлага, эрхийг тусгасан байна.
- 3.4. Аж ахуйн нэгж байгууллагатай байгуулах гэрээнд энэ зүйлийн 3.3-т зааснаас гадна дулааны хэрэглээний горим /сар, жилээр/, техникийн өгөгдлүүд, тоолуурын байршил, үндэслэл, аж ахуйн нэгж, байгууллагын харилцагч банкны байгууллагаас гаргасан баталгаа, тэдгээрийн харилцах данснаас төлбөрийг банкны байгууллагаар шууд хийлгэх нөхцөл, төлбөрийн барьцаа болон шаардлагатай бусад асуудлуудыг тусгана.
- 3.5. Дулаанаар хангагдаж буй барилга байгууламжийг өөр этгээдийн өмчлөл, эзэмшилд шилжүүлвэл хангагчтай байгуулсан гэрээг 7 хоногийн өмнө цуцалж, төлбөр тооцоог дуусгасан байна.
- 3.6. Хангагч, хэрэглэгч нь дулаанаар хангах гэрээг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ний дотор байгуулж, гэрээг улирал бүр дүгнэнэ.
- 3.7. Хангагч нь дулааны үнэ, тарифт өөрчлөлт орсон талаар түүнийг мөрдөж эхлэхээс 10- аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчдэд мэдэгдэнэ. Хэрэглэгч нь энэ тухай мэдэгдсэнээс хойш 10 хоногийн хугацаанд багтаан гэрээндээ өөрчлөлт оруулаагүй нь уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.
- 3.8. Хэрэглэгчийн шугам сүлжээний заагийг тухайн шугам сүлжээний өмчлөлийн харьяаллаар тогтооно.

- 3.9. Хангагч нь хэрэглэгчийн хүсэлтээр тэдгээрийн шугам, тоноглолд төлбөртэй үйлчилгээ үзүүлж болох бөгөөд үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг Нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн газар тогтооно.
- 3.10. Дулааны тасалдлаас учирсан шууд ба шууд бус хохирлыг нөхөн төлөх талаар дулаанаар хангах гэрээнд тодорхой тусгасан байна.

Дөрөв. Хангагчийн эрх, үүрэг

- 4.1. Хангагч нь Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, аж ахуйн харилцааны дүрэм, хэрэглэгчтэй байгуулсан гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 4.2. Хангагч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дулаанаар хангах гэрээ байгуулахаас болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзах эрхгүй.
- 4.3. Хангагч нь хэрэглэгчийг өндөр нарийвчлал бүхий битүүмжлэл сайтай тооцооны хэрэгслээр хангах ба хангагчийг энэ үүргээ хэрэгжүүлэхэд нь хэрэглэгч саад учруулах эрхгүй.
- 4.4. Хангагч нь дулааны шугам, тоноглолын хамгаалалтын зурваст барилга барих болон бусад үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хамгаалалтын зурвасыг чөлөөлөхийг шаардсан мэдэгдэл шаардлага өгч, уг шаардлагыг үл биелүүлбэл орон нутгийн засаг захиргаа болон хуулийн байгууллагад энэ тухай тавьж шийдвэрлүүлнэ.
- 4.5. Хангагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хэрэглэгчийн дулаан хангамжийг Эрчим хүчний тухай хууль болон гэрээнд заасны дагуу түдгэлзүүлж зөрчлийг арилгахыг шаардана. Зөрчил арилсан тухай бүрд хэрэглэгчийг дулаанаар саадгүй хангах бөгөөд хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас дулаан хангамжийг тасалснаас үүссэн хохирлыг хангагч хариуцахгүй.
- 4.6. Хангагч нь хэрэглэгчийг Эрчим хүчний зохицуулах газраас баталсан холболтын зааврын дагуу төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбоно.
- 4.7. Хангагч нь хэрэглэгчийн хэрэглэх дулааны хэмжээнд тооцож тавьсан тохируулах хэрэгслийг шалгаж битүүмжилнэ.
- 4.8. Хангагч нь дулааны төлөвлөгөөт таслалтын талаар хэрэглэгчид 4-өөс доошгүй цагийн өмнө мэдэгдэнэ.

Тав. Хэрэглэгчийн эрх, үүрэг

- 5.1. Дулаан хэрэглэгч нь Монгол Улсын Иргэний хууль Эрчим хүчний тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.
- 5.2. Хэрэглэгч нь шугам сүлжээнд шинээр холбогдох, өөрийн дулааны ачаалалыг өөрчлөх тухай бүрт хангагчаас техникийн нөхцөл авах бөгөөд хангагчийн зөвшөөрлөөр бусад хэрэглэгчийг өөрийн эзэмшлийн тоног төхөөрөмж, шугам сүлжээнд холбуулах үүрэгтэй. Өөрийн эзэмшлийн шугам сүлжээнд дур мэдэн бусад хэрэглэгчийг холбох, тэдгээртэй дулаанаар хангах аж ахуйн гэрээг байгуулахыг хориглоно.
- 5.3. Хангагчтай тооцоо хийдэг тоолуурын бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцаж, гэмтэл гарсан болон гарч болзошгүй тохиолдолд хангагчид яаралтай мэдэгдэх үүрэгтэй.
- 5.4. Хэрэглэгч нь тооцоолон тавьсан тохируулах хэрэгслийн битүүмжлэлийг хариуцна.
- 5.5. Хэрэглэгч нь хангагчийн эрх бүхий ажилтныг дулааны узель, салаа шугамын шугам хоолой, хаалт, арматур, дулааны тоолуур болон хянах, хэмжих тохируулах, хэрэгслийн ажиллагаа, заалтыг шалгах зорилгоор объектод чөлөөтэй нэвтрүүлж, тавигдсан шаардлагыг биелүүлж ажиллана.
- 5.6. Барилга, орон сууцны халаалтын болон өөрийн эзэмшлийн шугамын усыг буулгаж засвар үйлчилгээ хийхдээ хангагчаас зөвшөөрөл авах бөгөөд сүлжээний усыг асгах болон бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.
- 5.7. Хэрэглэгч нь дулаанаар хангах аж ахуйн гэрээнд заасан хугацаанаас өмнө дулаанаа хаалгах бол энэ тухай захиалгыг хангагчид 7-оос доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 5.8. Хэрэглэгч нь дулааны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх үүргийг хүлээх бөгөөд энэ үүргийг биелүүлээгүй бол хууль болон гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.
- 5.9. Хэрэглэгч нь тоо хэмжээ, чанар, стадартын шаардлага хангаагүй дулаан нийлүүлсэн тухай бүрд нь хангагчид мэдэгдэж, хэвийн болгохыг шаардах эрхтэй.
- 5.10. Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшлийн барилга, объектоо бусад иргэн, аж ахуйн нэгжид түрээслэсэн бол дулаанаар хангах гэрээг өөрийн нэр дээр байгуулж, дулааны төлбөрийг хариуцна.
- 5.11. Хэрэглэгчийн буцах усны температур нь батлагдсан графикаас өндөржсөн тохиолдолд бууруулах арга хэмжээг хангагчтай хамтран хэрэгжүүлнэ.

- 5.12. Хэрэглэгч өөрийн эзэмшлийн дулааны шугам тоног төхөөрөмжид шаардлагатай засвар үйлчилгээ, туршилт, тохируулгыг хийж, хэвийн найдвартай ажиллагааг хангах үүрэгтэй.
- 5.13. Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн дулааны хэмжих, тохируулах хэрэгслийн ашиглалт, засвар үйлчилгээ, баталгаажуулалт, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 5.14. Хэрэглэгч нь тоолуурыг зөөж байрлуулах, ээлжит баталгаажуулалт хийлгэх бол хангагчийн эрх бүхий ажилтныг байлцуулан гүйцэтгэх бөгөөд уг ажиллагаанаас гарах зардлыг хэрэглэгч хариуцна.

Зургаа. Үйлчилгээний түвшин

- 6.1. Хангагч нь хэрэглэгчийг аж ахуйн гэрээнд заасан тоо хэмжээ, чанарын шаардлага хангасан дулаанаар найдвартай хангана.
- 6.2. Хангагч нь дулааны тасалдлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, машин механизм, хүн хүч, тоног төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгана.
- 6.3. Хэрэглэгчийн захиалгаар ажил гүйцэтгэх үед бусад хэрэглэгчийн дулаан хангамжийг түдгэлзүүлэх бол энэ тухайгаа холбогдох хэрэглэгчид 48 цагийн өмнө мэдэгдэнэ.
- 6.4. Дулааны хэрэглэгчээс барилга, объектод техникийн нөхцөл авахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авсанаас хойш хангагч нь хуанлийн 14 хоногийн дотор шийдвэрлэж хариу өгнө.
- 6.5. Дулаан хангамжийн талаарх хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногт багтаан хариу өгнө.

Долоо. Дулааны чанарын үзүүлэлт

- 7.1. Хангагч нь Диспетчерийн үндэсний төвөөс тогтоосон горимыг мөрдөж ажиллана. /даралт $\pm 5\%$, температур $\pm 4^{\circ}\text{C}$ -аас ихгүй хэлбэлзэлтэй байна/
- 7.2. Хэрэгцээний халуун усны халаагч суурилагдсан дулаан дамжуулах төв болон дулааны зангилаанд хэрэгцээний халуун усны халууныг $55-60^{\circ}\text{C}$ байхаар тохируулна.

Найм. Дулааны төлбөр, тооцоо

- 8.1. Хангагч нь төлбөр тооцоондоо ЭХЗГ- аас баталсан үнэ тарифыг мөрдөнө.

- 8.2. Хэрэглэгчийн тоолуурын заалтын бичилтыг гэрээнд заасан хугацаанд хийж, хэрэглэсэн дулааны төлбөрийн хэмжээг тогтооно.
- 8.3. Тоолуургүй хэрэглэгчийн төлбөр, тооцоог тухайн барилга, объектын зураг төсөвт заасан талбай, эзэлхүүн, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг үндэслэн хийнэ.
- 8.4. Хангагч нь хэрэглэгчийн хэрэглэсэн дулааны хэмжээг хэрэглэгчийн шугамын эзэмшлийн зааг дээрээс эхлэн тооцно. Тоолуурыг шугамын эзэмшлийн заагаас зайтай байрлуулсан бол хэрэглэгчийн дулааны тооцоонд шугамын алдагдлыг нэмж тооцно.
- 8.5. Төлбөр тооцооны хэмжих хэрэгсэл, тоолуур нь Стандарчилал хэмжил зүйн үндэсний төвөөр баталгаажиж, битүүмжлэгдсэн байна.
- 8.6. Хэрэглэгчийн тоолуур гэмтэлтэй буюу ашиглах боломжгүй болсон үед хэрэглэсэн дулааны төлбөрийн хэмжээг тоолуургүй хэрэглэгчийн тарифыг үндэслэн тогтооно.
- 8.7. Хэрэглэгч нь өөрийн буруугаас сүлжээний буцах усны халууныг графикаас 4 хэмээс дээш хэмжээгээр өндөржүүлсэн тохиолдолд өндөржүүлсэн хэмд ногдох дулааны үнийг төлнө.
- 8.8. Хэрэглэгч нь хэрэглэсэн дулааны төлбөрийг хангагчаас өгсөн нэхэмжлэх, бусад төлбөр тооцооны баримтын дагуу тухайн сардаа багтаан төлнө.
- 8.9. Хэрэглэгч нь эрчим хүчээр хангах гэрээнд өөрөөр заагаагүй бол сард хэрэглэх дулааны үнийн 50 хувьтай тэнцэх төлбөрийг хангагчид тухайн сарын 10-ны дотор урьдчилан төлнө.
- 8.10. Хэрэглэгч нь дулааныг зүй бусаар хэрэглэсэн бол хангагч нөхөн тооцоог хийж, хариуцлага хүлээлгэнэ.
- 8.11. Тооцооны хэмжих хэрэгсэл болон тооцоо хийсэн ажилтны буруугаас гарсан төлбөр тооцооны зөрүүг хангагч, хэрэглэгч харилцан тохиролцож дараа сарын тооцоонд оруулан нөхөн тооцоо хийнэ.

Ес. Хангагчаас хэрэглэгчийн дулаан хангамжийг түдгэлзүүлэх

- 9.1. Эрчим хүчний тухай хууль, энэ дүрэм, гэрээнд заасан үндэслэлээр хангагч нь хэрэглэгчийн дулаан хангамжийг түдгэлзүүлнэ.
- 9.2. Хангагч нь дулааны төлөвлөгөөт таслалтын талаар график гарган хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд урьдчилан мэдэгдэнэ.

9.3. Хангагч нь дараахь тохиолдолд дулаан хангамжийг хэрэглэгчид урьдчилан мэдэгдэлгүйгээр түдгэлзүүлнэ:

9.3.1. Хангагчийн дулааны шугам сүлжээ, тоног төхөөрөмжид аваарь, осол гарсан буюу гарч болзошгүй байдал бий болсон,

9.3.2. Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн

9.4. Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 32.2 дахь хэсэгт зааснаас гадна дулаанаар хангах гэрээнд тусгайлан заасан тохиолдолд дараахь үндэслэлээр хэрэглэгчийн дулааны хэрэглээг урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

9.4.1. Дулааныг гэрээнд заагаагүй зориулалтаар ашигласан, ус, дулааны алдагдлыг нормт хэмжээнээс хэтрүүлсэн

9.4.2. Дулаан хэрэглэх техникийн нөхцөлийг бүрдүүлээгүй буюу техникийн нөхцлийн шаардлагыг хангаагүй, эсхүл зөвшөөрөлгүйгээр шинэ барилга байгууламжийг дулааны сүлжээнд холбож дулаан авсан

9.4.3. Хангагчаас тооцоолж битүүмжилж тавьсан дулаан тохируулах хэрэгсэл /сопло, шайба/-ийг дур мэдэн өөрчилсөн буюу зөвшөөрөлгүйгээр дулаан авч бусдын дулаан хангамжийг доголдуулсан

9.4.4. Тооцооны хэмжих хэрэгслээр тооцох боломжгүй холболт хийж дулаан авч ашигласан

9.4.5. Хэрэглэсэн дулааны үнэ болон нөхөн тооцооны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй

9.4.6. Эрчим хүчний улсын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй

9.5. Дулааны хэрэглээг түдгэлзүүлэх тухай мэдэгдлийг хангагчийн эрх бүхий ажилтан / улсын байцаагч/ хэрэглэгчид биеэр болон шуудангаар хүргүүлнэ. Мэдэгдэлд түдгэлзүүлэх болсон шалтгааныг тодорхой зааж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ, тоолуур болон шаардлагатай бусад хэрэгслийг хангагчийн эрх бүхий ажилтан битүүмжилнэ.

9.6. Дулааны хангамж, хэрэглээгээ түдгэлзүүлсэн хэрэглэгч нь түдгэлзүүлсэн шалтгааныг арилгасан тухайгаа хангагчид мэдэгдэж шалгуулахаас өмнө тоног төхөөрөмж, шугам сүлжээ ашиглан дур мэдэн дулаан холбохыг хориглоно.

**Арав. Гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдал үүссэн
нөхцөлд ажиллах журам**

10.1. Эрчим хүчний үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа алдагдаж, дулаан хангамж тасалдан, улс нийгэмд ноцтой хохирол учирч болох онцгой нөхцөл байдал бий болсон үед хангагч нь эрх бүхий байгууллагаас баталсан “Байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал

үүссэн тохиолдолд эрчим хүчний үйлдвэр, байгууллагуудын мөрдөх журам"-ыг мөрдлөг болгон ажиллана.

- 10.2. Хангагч нь байгаль цаг уурын онцгой нөхцөл байдалд ажиллах журмыг баримтлан дулааны шугам сүлжээнд гарсан аваарийг богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээг авч ажиллах бөгөөд дулаан хангамжийг сэргээхэд шаардагдах хугацаа, залгалт хийж эхлэх хугацааг хэрэглэгчид мэдээлж байна.

Арван нэг. Дулааны хангамж, хэрэглээтэй холбогдсон өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх

- 11.2. Хангагч нь дулааны хангамж, хэрэглээтэй холбогдож хэрэглэгчээс гаргасан өргөдөл, гомдлыг өөрийн байгууллагад мөрдөж буй журмын дагуу хүлээн авч шийдвэрлэнэ.
- 11.3. Хангагч нь хэрэглэгчээс гаргасан өргөдөл, гомдлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжгүй бол холбогдох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 11.4. Хэрэглэгч нь хангагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо холбогдох дээд байгууллага болон шүүхэд гаргаж болно.

Арван хоёр. Хангагч, хэрэглэгчийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэх, хохирлыг нөхөн төлөх

- 12.1. Хангагч, хэрэглэгчийн хооронд гарсан маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 12.2. Хангагч, хэрэглэгчийн хооронд тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагаатай холбоотой гарсан маргааныг шийдвэрлэхдээ мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах шаардлагатай бол зөвхөн Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөр дүгнэлт гаргуулна.
- 12.3. Хангагч, хэрэглэгчийн хооронд дулаанаар хангахтай холбогдсон харилцаанаас үүссэн хохирлыг хангагч, хэрэглэгчийн хамтран тогтоосон актаар баталгаажуулна.
- 12.4. Хохирлын актыг холбогдох талууд хамтран ажлын 5 хоногийн дотор тогтоож баталгаажуулах бөгөөд хохирлыг буруутай тал 2 сарын дотор нөхөн төлнө.
- 12.5. Хэрэглэгч нь өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа тоног төхөөрөмждөө засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс хангагч болон бусад этгээдэд хохирол учруулсан бол учруулсан шууд хохирлыг нөхөн төлнө.

12.6. Дараахь тохиолдолд хэрэглэгчид учирсан хохирлыг хангагч хариуцахгүй:

12.6.1. Байгалийн гэнэтийн аюул / аянга, салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр г.м / тохиолдсон

12.6.2. Хангагчтай тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүй

12.6.3. Эрчим хүчний тухай хуулийн 29.1.2, 32.2, 32.3-д заасны дагуу хэрэглэгчийн дулааны хангамжийг түдгэлзүүлсэн

12.6.4. Хэрэглэгчийн дулааны шугам, тоноглолыг гуравдагч этгээд гэмтээсэн

12.6.5. Хэрэглэгч Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм зөрчсөн

**Арван гурав. Дүрмийн биелэлтэнд тавих хяналт,
хүлээлгэх хариуцлага**

13.1. Энэхүү дүрмийн биелэлтэнд хангагч, хэрэглэгч талууд болон Эрчим хүчний зохицуулах газар, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч хяналт тавина.

13.2. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага олон нийтийн хяналт тавина.

13.3. Энэхүү дүрмийг зөрчсөн этгэдэд Эрчим хүчний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.